



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН С.ЭРДЭНЭБОЛД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД**

Засгийн газрын VII байр, Энхтайвны өргөн чөлөө 51,  
Банзар дүүрэг, Улаанбаатар хот, 13330  
Утас: 25 35 31, Факс: (976-11) 45 81 12,  
Цахим ирүүдэл: info@med.gov.mn,  
Цахим хуудас: www.med.gov.mn

2026.02.10 № 1а/547

таний \_\_\_\_\_ -ий № \_\_\_\_\_ -т

Мэдээлэл, судалгаа хүргүүлэх тухай

Таны 2026 оны 01 дугаартай "Хүний амьд явах эрхийн хэрэгжилтийн тухай" албан бичгээр ирүүлсэн асуулгатай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "амьд явах" үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх тухай эрх зүйн зохицуулалтын хүрээнд эрх бүхий байгууллагуудаас авсан судалгаа болон Зэвсэгт хүчинд цэргийн алба хаах явцдаа амьд насдаа алдсан, биеийн эрүүл мэндээрээ хохирсон цэргийн алба хаагчдын талаарх судалгаа, тайланг нэгтгэн хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.



Батлан хамгаалах яам  
Батлан хамгаалахын сайд  
Д.Батлут  
2026.02.10 18:25

## МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

1. Улсын ерөнхий прокурорын ирүүлсэн Зэвсэгт хүчний цэргийн алба хаагч Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг үйлдсэн болон хохирсон талаар тоон судалгаагаар 2014-2025 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 52 хэрэг, үүнээс хааж шийдвэрлэсэн 5, хэрэгсэхгүй болгосон 4, шүүхэд шилжүүлсэн 42 хэрэг, гэмт хэргийн улмаас хөнгөн хохирол учирсан 9, хүндэвтэр хохирол учирсан 2, хүнд хохирол учирсан 2, амь нас хохирсон 1, эд хөрөнгийн хохирол учирсан 2 цэргийн алба хаагч бүртгэгдсэн байна.

Мөн Цагдаагийн байгууллагад 2010-2025 онд бүртгэгдсэн Зэвсэгт хүчний алба хаагч гэмтсэн гэмт хэргийн судалгаагаар нийт 447 хэрэг бүртгэгдсэн байна. Тухайлбал, албан үүргээ гүйцэтгэх үед эрүүл мэндэд нь хүнд болон хөнгөн хохирол учирсан нийт 33 цэргийн алба хаагч, нас барсан болон амиа хорлосон нийт 27 цэргийн алба хаагч бүртгэгдсэн байна.

2. Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штаб нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа, хяналт тавих, хэрэг хянан шийдвэрлэх, мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах, хяналт тавих, хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад хамаардаггүй болно.

Зэвсэгт хүчин нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах үндсэн чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага бөгөөд Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт тайван цагт хүлээх үүргийг хуульчилсан.

Түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтад заасны дагуу Зэвсэгт хүчин нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага юм.

Зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги, байгууллага тус бүрт "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл"-ийг байгуулан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд, Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг биелүүлэх, аливаа төрлийн гэмт хэрэг, хүний эрхийн зөрчил, дүрмийн бус харилцааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг сурталчлах, алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, цэргийн албыг хэвшүүлэх, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, ёс зүйн шаардлагыг сахиулах, байгууллагын соёлыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг.

Нөгөөтээгүүр, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэргийн алба хаагчдын талаар иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг үндэслэн Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан

өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоодын хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/375 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам", 2020 оны А/294 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны А/07 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Зэвсэгт хүчинд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг удирдлага болгож, батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний хяналт-шинжилгээ, үнэлгээ газраас хяналт, шалгалтыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр зохион байгуулж, зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авч, үр дүнг тооцож ажилладаг.

Тухайлбал, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбарт 2021-2025 онд 114 төлөвлөгөөт шалгалт, 230 төлөвлөгөөт бус шалгалт, нийт 344 хяналт, шалгалтыг явуулсан байна.

Цэргийн алба, сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн алба, сэтгэл зүйн хангалтын газраас цэргийн албаны төлөвлөгөөт шалган туслах ажлыг батлагдсан хуваарийн дагуу Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагад зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг засах хугацаатай үүрэг чиглэл өгч, цаашид анхаар асуудлын хүрээнд зөвлөгөө, зааварчилгаагаар ханган ажилладаг.

Цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ эрүүл мэндэд нь хүнд, хөнгөн хохирол учирсан, нас барсан бол тухайн цэргийн алба хаагчид, эсхүл ар гэрт нь Төрийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу холбогдох тэтгэвэр, тэтгэмжийг олгох асуудлыг шийдвэрлүүлж байна.

Хүний эрхийг хангах хүрээнд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс хамтран 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан "Монгол Улсын Их Хурлын 2022 оны 49 дүгээр, 2023 оны 35 дугаар тогтоолын хэрэгжилт, цаашид анхаарах асуудал" сэдэвт хэлэлцүүлгээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2022 онд гаргасан "Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл", мөн Улсын Их Хурлын 2022 оны "Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 49 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн "б"-д заасан арга хэмжээг "хэрэгжсэн" гэж дүгнэсэн бол "а" болон "в"-д заасан арга хэмжээнүүд хугацаа шаардагдах тул "хэрэгжих шатанд" гэж тус тус дүгнэгдсэн.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлд заасны дагуу хүний эрхийн зөрчил гарах болсон буюу гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцөлийг арилгуулах тухай мөрдөгч, прокурорын мэдэгдлээс гадна Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээс ирүүлсэн шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилтийг холбогдох албан тушаалтанд тайлагнадаг.

3. Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд 2024 онд Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр цэргийн алба хаагчид хууль тогтоомжид заасан ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд аливаа дарамт, шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхахыг хориглосон.

Мөн дүрмийн бус харилцаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлын хүрээнд Монгол Улсын Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 01 дүгээр зарлигийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Цэргийн дотоод албаны дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсэгт "Цэргийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэх үедээ Цэргийн нийтлэг дүрмүүдээр тогтоосон хэм хэмжээг зөрчиж хоорондоо харилцахыг дүрмийн бус харилцаа гэж үзнэ." гэж тодорхойлсон.

Өөрөөр хэлбэл, цэргийн алба хаагч дүрмийн бус харилцаа гаргасан тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 28.13 дугаар зүйлд заасан Дотоод албаны журам зөрчих гэмт хэргийн шинжтэй гэж үзэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан "Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт" сэдэвт сонголд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал С.Ганбямба "Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад хүний эрх, эрх чөлөөг зөрчих, дүрмийн бус харилцааны талаар гаргасан гомдол, мэдээллийн шийдвэрлэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээ"-ний талаар мэдээлэл хийсэн.

Түүнчлэн, Батлан хамгаалах яам, Хүний эрхийн Үндэсний Комисс 2022 онд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын болон хүмүүнлэгийн эрх зүйн гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон цэргийн алба хаагчдын хуульд заасан эрхийг баталгаатай хангуулах, цэргийн нэгтгэл, анги, байгууллага дахь дүрмийн бус харьцаа, хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цэргийн алба хаагчдад хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх зорилготой "Хамтран ажиллах санамж бичиг"-ийг байгуулсан.

Энэхүү санамж бичгийн хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штабаас Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран "Хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалт"-ыг зохион байгуулдаг бөгөөд 2024 онд 45 сургагч багш, 2025 онд 33 сургагч багшийг тус тус бэлтгэж, гэрчилгээ олгосон.

Зэвсэгт хүчний хүний эрхийн сургагч багш нар өөрийн алба хааж буй төрлийн цэргийн командлал, удирдах газар, харьяа нэгтгэл, анги, салбар, байгууллагын алба хаагчдад бие дааж болон Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутаг дахь референтуудтай хамтран сургалтыг зохион байгуулдаг.

Тодруулбал, зөвхөн Тусгай хүчний цэргийн командлал, харьяа нэгтгэл, ангийн сургагч багш нар 2025 онд 21 удаагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 2,600 гаруй алба хаагчийг хамруулсан байна.

Түүнчлэн, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчдад хүний эрхийн конвенц болон холбогдох хууль тогтоомжийн талаар мэдлэг олгох сургалтыг 2024, 2025 онд тус тус зохион байгуулж, нийт 1700 алба хаагчийг хамруулсан.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд ёс зүй, харилцаа хандлага, сэтгэц, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, мэргэжлийн ёс зүйн үйлчилгээ, оношилгоо үзүүлэх, зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн мэдлэг, боловсролыг олгох зорилгоор Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2026 оны .... дугаар тушаалаар 3 дахь удаагаа Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлгийг томилон Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад батлагдсан хуваарийн дагуу ажиллуулж байна.

Монгол Улсын иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэгт “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;” гэж хуульчилсан.

Дээрх хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг хангах хүрээнд өргөдөл, гомдлыг биечлэн, утсаар, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс хуваарилагдаж ирсэн, шуудангаар, Зэвсэгт хүчний Жанжин штабын цахим хуудас, олон нийтийн сүлжээ, албаны цахим хаягаар зэрэг нийт 7 сувгаар хүлээн авч, бүртгэл хөтлөлтийг хийж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хуульд заасан хугацаанд хүргүүлэн ажилладаг.

Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, харьяа нэгтгэл, анги, байгууллагад 2025 онд иргэдээс нийт 13086 өргөдөл, гомдол ирүүлсэн бөгөөд 99.34 хувьтай шийдвэрлэсэн.

Жендэрийн тэгш байдлыг хангах хүрээнд Бүгд Найрамдах Словени Улстай хамтран Жендэрийн тэгш байдлын элч–Монголын энхийг сахиулагчид” төслийг 2024 онд хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвийн материаллаг баазын түшиглэн “Энхийн ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад Зэвсэгт хүчин, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын нийт 20 цэргийн алба хаагч болон Словени, Итали, Финланд улсаас сургагч багш нар оролцсон. Сургалтад оролцогчид Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийн ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед тулгардаг жендэрийн тэгш байдалтай холбогдолтой асуудлыг бууруулах, цаашид ажил, алба болон ажиллагааны газар оронд жендэрийн тэгш байдлыг хангахад манлайлал үзүүлэх мэдлэг олж авсан.

Дээрх төслийн II шатыг Европын холбооны дэмжлэгтэйгээр 2024 оны 11 дүгээр сарын 18-наас 28-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Словени Улсад зохион байгуулж, “Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед жендэрийн тэгш байдлыг хангах нь” сэдэвт сургалтад Зэвсэгт хүчний 22 цэргийн алба хаагч хамруулсан байна.

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ**

Батлан хамгаалахын сайдын  
2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн  
1а/547 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДЭД НЬ ХҮНД БОЛОН ХӨНГӨН ХОХИРОЛ УЧИРСАН АЛБА ХААГЧДЫН СУДАЛГАА

Д/д	Д/д	Хэргийн дугаар	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг	Алба хаагчийн мэдээлэл/ Мэдээлэл гаргасан хүн			Хэргийн товч утга	Ажил эрхлэлт
				Овог	Нэр	Хүйс		
1	2	3	4	5	6	7	8	9
2010 он								
1	1	21028053	278.1.Бие биедээ захирагдахгүй цэргийн албан хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих	Хулан	Ононбаяр	Эр	Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн салаан захирагч Гүрдагва иргэн Өлзийсайханг зодож гэмтээсэн.	Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
2	2	21010292	277.3.Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх	Батмөнх	Жанчивдорж	Эр	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн байлдагч Б.Жанчивдорж бусдад зодуулж хүнд гэмтсэн.	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
3	3	21018129	283.1.Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад	Даваа	Давааням	Эр	Нямцоо нь галт зэвсэг хүлээлцэж байгаад гал алдаж бусдын биед гэмтэл учруулсан.	Зэвсэгт хүчний 123 дугаар анги

		хэрэгсэлтэй харьцах журам зөрчих							
2011 он									
4	1	21142226	280.1.Биедээ гэмтэл учруулах буюу өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх	Цагаанцоож	Төмөрбаатар	Эр	Зэвсэгт хүчний 310 дугаар харуул 2011 оны 08 дугаар сарын 27-ны өдөр өөрийгөө буудсан.	Зэвсэгт хүчний 310 дугаар анги	
5	2	21103319	181.3.Танхайрах	Төмөр	Батбаяр	Эр	Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн алба хаагч хошууч Батжаргал нь дэслэгч Батсүхтэй маргалдаж байлдааны галт зэвсгээр 2 удаа буудаж танхайрсан.	Зэвсэгт хүчний 310 дугаар анги	
6	3	21112131	277.1.Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх	Хүрэлхүнай	Мөнхнаран	Эр	Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн захирагч Ж.Насанжаргал Х.Мөнхнаранг зодсон.	Зэвсэгт хүчний 338 дугаар ангид ахлагч	
7	4	201219000228	277.1.Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх	Эрдэнээ	Ууган-Эрдэнэ	Эр	Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн ахлагч Жигжид нь дэд ахлагч Ууган-Эрдэнийг зодож гэмтээсэн.	Зэвсэгт хүчний 119 дүгээр ангид дэд ахлагч	
2012 он									
-	-	-	-	-	-	-	-	-	-
2013 он									
8	1	201301080197	277.1.Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх	Сугар	Даваажав	Эр	Зэвсэгт хүчний 014 дүгээр анги хээрийн сургалтанд гарч байх үед дэд ахлагч Энх-Орпил нь байлдагч С.Даваажавыг зодож биед нь хөнгөн гэмтэл учруулсан.	Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагч	

9	2	2013190000595	277.2.Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх	Сайнбаяр	Ганболд	Эр	Төв аймгийн Алтанбулаг суманд Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн байлдагч С.Ганболдыг ахлагч Б.Ганхуяг нь зодож, хүндэвтэр гэмтэл учруулсан.	Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагч
2014 он								
10	1	201411000429	278.2.Бие биедээ захирагдахгүй цэргийн албан хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих	Хүрэлмүжаан	Лхагва-Очир	Эр	Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн байлдагч Лхагва-Очирыг бага дарга Пүрэвжав нь цохиж биед хүндэвтэр гэмтэл учруулсан.	Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
11	2	201410000094	183.1.Аюулгүй ажиллагааны журам зөрчих	Ганзориг	Чинзориг	Эр	Дорноговь аймгийн Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт баригдаж байсан барилгаас унаж гэмтсэн.	Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
2015 он								
12	1	2015190000201	277.1.Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх	Арьяа	Гэрэлтболор	Эр	Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн ротын захирагч ахмад Д.Булганням нь согтуугаар байлдагч Гэрэлтболорыг зодсон.	Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн гэрээт цэргийн алба хаагч
2016 он								
13	1	2016090000168	283.1.Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад	Цолмон	Мөнхзул	Эр	Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн хашаанд сумны хошуу мэт зүйл	Зэвсэгт хүчний 330

		хэрэгсэлтэй харьцах журам зөрчих	Орсоо	Ууганбаяр	Эр	тэсэрч Ц.Мөнхзул, П.Эрдэнэ-Очир, Б.Алтанбагана нар гэмтсэн	дугаар ангид ахлагч
2017 он							
14	1		Орсоо	Ууганбаяр	Эр		Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн цэргийн цагдаа
15	2	283.2.Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих	Лхагвасүрэн	Очирбат	Эр	Зэвсэгт хүчний 350 дугаар ангид мэргэн буудагч	Зэвсэгт хүчний 350 дугаар ангид мэргэн буудагч
16	3	201719000224	Жаргалсайхан	Бадмаанямбуу	Эр	Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн бие бүрэлдэхүүн хээрийн сургалт явагдах үеэр ахлагч Б.Ариунболд нь хамгаалалтын түгжээг нь мулталсан гранатаа газар унагаснаас тэсрэлт үүсэж, хажууд нь зогсож байсан зэвсгийн албаны дарга ахмад Батсуурийн Мөнгөншагайгийн хамт нас барж, 11 хүн шархадсан.	Зэвсэгт хүчний 350 дугаар ангид жолооч, буудагч
17	4		Төмөр-Очир	Анхбаяр	Эр		Зэвсэгт хүчний 350 дугаар ангид буудагч
18	5		Дорж	Батболд	Эр		Зэвсэгт хүчний 350 дугаар ангид буудагч
19	6	201714000152	Лхагвадорж	Хүдэрчулуун	Эр	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн зэвсэг, техник хадгалах агуулахад Л.Хүдэрчулуун нь цэвэрлэгээ хийж байгаад гранатын тэсрүүлэгчийн түгжээг татсаны улмаас тэсэрч гар болон нүүрэн хэсэгтээ гэмтэл авсан.	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хугацаат

									цэргийн алба хаагч	
2018 он										
20	1	182100300.0312	28.9.1. Байлдааны зөвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих	Дүгэр	Энхбаатар	Эр	Зөвсэгт хүчний 085 дугаар салбарын буудлагын талбайд хошууч М.Нармандах нь галт зөвсэгтэй болгоомжгүй харьцсаны улмаас ПМ маркийн буугаар ахлах ахлагч Энхбаатарын цээжин тус газарт буудаж гэмтэл учруулсан.			Зөвсэгт хүчний 085 дугаар салбарт ахлагч
21	2	180602491.0207	28.3.1. Дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх	Ганцогт	Азаяа	Эр	Зөвсэгт хүчний 110 дугаар ангийн байдагч Б.Азаяа нь бусдад зодуулж, эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол учирсан.			Зөвсэгт хүчний 110 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
2019 он										
22	1	192800118.01.05	28.6.1. Биедээ гэмтэл учруулах, өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх	Хүрэлчулуун	Бат-Амгалан	Эр	Зөвсэгт хүчний 167 дугаар ангийн тавиулангийн хашаанд байлдагч Х.Бат-Амгалан биедээ галт зөвсгийн шархтай байсан.			Зөвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
2020 он										
23	1	200700178	11.6.1. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	Намсрай	Баярцэнгэл	Эр	Зөвсэгт хүчний 353 дугаар ангийн гал тогооны заланд Н.Баярцэнгэл, Ш.Цогтсайхан, Б.Билгүүн нар хоорондоо зодолдсоны улмаа Н.Баярцэнгэл, Ш.Цогтсайхан нарын эрүүл мэндэд хөнгөн хохирол учирсан.			Зөвсэгт хүчний 353 дугаар ангид батарейн захирагч
24	2			Ширэндэв	Цогтсайхан	Эр				Зөвсэгт хүчний 353

									дугаар ангид батарейн захирагч
25	3	203600000.0126	28.3.1.Дарга, захирагч захирагдагчдаа хэрэглэх26	нь хүч	Батгэрэл	Бямбадорж	Эр	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн байлдагч Б.Бямбадорж бусдад зодуулсан.	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
2021 он									
-	-	-	-	-	-	-	-	-	-
2022 он									
-	-	-	-	-	-	-	-	-	-
2023 он									
26	1	231004344.0508	28.3.1.Дарга, захирагч захирагдагчдаа хэрэглэх	нь хүч	Зоригоо	Бат-Орших	Эр	Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч З.Бат-Орших бусдад зодуулж ГССҮТ-д хүргэгдсэн.	Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
27	2	233400204	11.6.1.Хүний мэндэд хохирол учруулах	эрүүл хөнгөн санаатай	Баянзаяа	Мөнгөншагай	Эр	Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч Б.Мөнгөншагайг дэд түрүүч Сүхбат зодож, чихний хэнгэрэгийг нь хагалсан.	Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч

28	3	232800034.00010	28.3.1.Дарга, захирагч захирагдагчдаа хэрэглэх нь хүч	Ганхуяг	Цэрэнням	Эр	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч Г.Цэрэнням бусдад зодуулсан.	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
29	4	230800000.16150	11.4.1.Хүний мэндэд хохирол учруулах эрүүл хөнгөн санаатай учруулах	Ганхуяг	Цагаан	Эр	Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид хоорондоо харилцааны зөрчил гаргаж б/ч Ш.Тамир б/ч Г.Цагааныг араас нь хавирч унагаахад, босож ирэн б/ч Ш.Тамирийн төмсөг тус газар өшиглөж гэмтээсэн.	Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
2024 он								
30	1	2425001134.0384	28.6.1.Биедээ гэмтэл учруулах, өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх	Болдбаатар	Мөнхцэрал	Эм	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч Б.Зодов нь биедээ гэмтэл учруулах, өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх үйлдэл гаргасан.	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
31	2	242800018	28.9.1. Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих	Батболд	Буян-Эрдэнэ	Эр	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч Б.Буян-Эрдэнэ харуулын үүрэг гүйцэтгэж байхдаа зүүн гарын дунд хурууг буудаж, гэмтээсэн.	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
32	3	243600449.0345	28.3.1.Дарга, захирагч захирагдагчдаа хэрэглэх нь хүч	Түмэндэмбэрэл	Эрдэнэбаяр	Эр	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Д.Цогтбаатар нь ахлах ахлагч Т.Эрдэнэбаяртай дүрмийн бус харилцаж, зодсон.	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн тагнуулын салааны



Батлан хамгаалахын сайдын  
2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн  
1а/547 дугаар албан бичгийн гуравдугаар хавсралт

АЛБАН ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭХ ҮЕДЭЭ НАС БАРСАН БОЛОН АМИА ХОРЛОСОН АЛБА ХААГЧДЫН СУДАЛГАА

Д/д	Д/д	Хэргийн дугаар	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг	Алба хаагчийн мэдээлэл/ Мэдээлэл гаргасан хүн			Хэргийн товч утга	Ажил эрхлэлт
				Овог	Нэр	Хүйс		
1	2	3	4	5	6	7	8	9
2010 он								
1	1	21018059	95.1.Бусдыг амиа хорлоход хүргэх	Төмөрхүү	Цэнд-Аюуш	Эр	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн мотобуудлагын даргаар ажиллаж байсан Т.Цэнд-Аюуш нь марштактик, тусгай бэлтгэлийн аварга салаа шалгаруулах тэмцээнд оролцож байгаад нас барсан	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн мотобуудлагын ротын жагсаалын дарга
2011 он								
-	-	-	-	-	-	-	-	-
2012 он								
2	1	201201020710	95.1.Бусдыг амиа хорлоход хүргэх	Алтанчимэг	Баярцэнгэл	Эр	А.Баярцэнгэл нь өөрийгөө буудаж нас барсан.	Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн алба хаагч

2013 он									
-	-	-	-	-	-	-	-	-	-
2014 он									
3	1	201401080079	95.1.Бусдыг амиа хорлоход хүргэх	Дамдин	Ганболд	Эр	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн байрлалд нас барсан.	Зэвсэгт хүчний 337 дугаар ангид жолооч	-
4	2	201408000133	284.2.Байлдааны машин жолоодох болон ашиглалтын журам зөрчих	Ганбат	Ганбаатар	Эр	Говьсүмбэр аймгийн Баянтал суманд Т-72 маркийн танк онхолдож, нас барсан.	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд механик жолооч	-
2015 он									
5	3	201501080552	285.1.Байлдааны болон сургуулийн нислэг хийх, түүнд бэлтгэх журам зөрчих	Нина	Батбаяр	Эр	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн орчим ми-8 нисдэг тэргийн ослоор нас барсан.	Зэвсэгт хүчний 337 дугаар ангид порттехникч	-
2016 он									
-	-	-	-	-	-	-	-	-	-
2017 он									
7	1	201719000224	283.2.Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих	Батямба	Ганзориг	Эр	Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн бие бүрэлдэхүүн хээрийн сургалт явагдах үеэр ахлагч Б.Ариунболд нь хамгаалалтын түгжээг нь мулталсан гранатаа газар унагаснаас тэсрэлт үүсэж, хажууд нь зогсож байсан зэвсгийн албаны дарга ахмад Батсуурийн Мөнгөншагайгийн хамт нас барж, 11 хүн шархадсан.	Зэвсэгт хүчний 350 дугаар ангид тасгийн захирагч	-
8	2			Батсуурь	Мөнгөншагай	Эр		Зэвсэгт хүчний 350 дугаар ангид зэвсгийн офицер	
9	3			Баасанжав	Ариунболд	Эр		Зэвсэгт хүчний 350 дугаар ангид буудагч	

10	4			Төрсайхан	Санжаа	Эр		Зэвсэгт хүчний 123 дугаар ангид хугацаат цэргийн алба хаагч
11	5	173600056.0094	10.4.1.Хүнийг хорлох амиа нөхцөл байдалд хүргэх	Баяндалай	Есөн-Эрдэнэ	Эр	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн 3 хугацаат цэргийн алба хаагч Ховд голд сэлж байгаад живж нас барсан.	Зэвсэгт хүчний 123 дугаар ангид хугацаат цэргийн алба хаагч
12	6			Мягмардорж	Батмөнх	Эр		Зэвсэгт хүчний 123 дугаар ангид хугацаат цэргийн алба хаагч
2018 он								
13	7	183100198	10.4.1.Хүнийг хорлох амиа нөхцөл байдалд хүргэх	Сүхбат	Мөнхжаргал	Эр	Алтанбулаг сумын 3 дугаар баг, Гүн нууранд ахлах ахлагч С.Мөнхжаргал усанд унаж нас барсан.	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангид салааны ахлагч
2019 он								
14	1	191900049.0019	28.3.1.Дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх	Батболд	Алтантулга	Эр	Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн ротын захирагч ахлах дэслэгч А.Энхбаяр, жолооч ахлагч Р.Вандлхангаа нар цэргийн амрах байрнаас гар утас олсон шалтгаанаар 7 хугацаат цэргийн алба хаагчийг хөнжил, пүүгээг нь үүрүүлээд биеийн тамирын талбай тойруулж, гүйлгэсний улмаас байлдагч Б.Алтантулгын бие муудаж, нас барсан.	Зэвсэгт хүчний 336 дугаар ангид хугацаат цэргийн алба хаагч
2020 он								

15	1		Ганбаяр	Гантулга	Эр		Зэвсэгт хүчний 110 дугаар ангид бетончин
16	2	203300090	Нямдалай	Батзориг	Эр	10.4.1.Хүнийг амиа хорлох нехцөл байдалд хүргэх	Зэвсэгт хүчний 110 дугаар ангид бетончин
17	3		Жавзанлагма	Анар-Эрдэнэ	Эр		Зэвсэгт хүчний 110 дугаар ангид бетончин
2021 он							
18	1	210700121	Дэлгэрням	Одонтулгалаг	Эм	10.4.1.Хүнийг амиа хорлох нехцөл байдалд хүргэх	Зэвсэгт хүчний 353 дугаар ангид оператор
19	2	211000000264	Цэрэндорж	Батгэрэл	Эр	10.1.1.Хүнийг алах	Зэвсэгт хүчний 326 дугаар ангид хугацаат цэргийн алба хаагч
20	3	212100172	Батбуян	Болд-Эрдэнэ	Эр	10.4.1.Хүнийг амиа хорлох нехцөл байдалд хүргэх	Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч
2022 он							
21	1	220604023.3129	3	Зангад	Эр	10.6.1.Хүний насыг болгоомжгүйгээр хохиороох	Зэвсэгт хүчний 017 дугаар ангид мужаан

										цохиулж Цэргийн төв эмнэлэгт хүргэгдэх явцдаа нас барсан.		
2023 он												
22	1	232300000.0197	10.1.1.Хүнийг алах	Лундаажав	Ням-Осор	Эр	Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн амрах байранд алба хаагч нар хоорондоо маргалдаж, Н.Эрхэмбаяр нь Л.Ням-Осорын гүрээ хэсэгт 1 удаа хутгалж, өөрийнхөө гүрээ хэсэгт 2 удаа хутгалсан. Улмаар Л.Ням-Осор нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байхдаа нас барсан.					Зэвсэгт хүчний 325 дугаар ангид планшетичин уншигч
23	2	233600194	10.4.1.Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Пүрэвдорж	Сүххуяг	Эр	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн байрлалд байлдагч П.Сүххуяг өөрийгөө боомилсон байдалтай нас барсан.					Зэвсэгт хүчний 123 дугаар ангид хугацаат цэргийн алба хаагч
2024 он												
24	1	243400667	10.4.1.Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Мажиг	Ганзориг	Эр	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд нас барсан.					Зэвсэгт хүчний 016 дугаар ангид алба хаагч
2025 он												
25	1	253400075	10.4.1.Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Төмөрчөдөр	Баттогтох	Эр	Төв аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр багт машин дээрээс унаж нас барсан.					Зэвсэгт хүчний 353 дугаар анги

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ